



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/462

Мөрөн сум

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 1.22 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.2, 9.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хуульд заасан шаардлагыг хангаж буй "Гранд Камел" ХХК-д 5 жилээр олгосугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

3. Хууль, эрх зүйн хэм хэмжээний актыг мөрдөж үйл ажиллагаа явуулахыг "Гранд камел" ХХК-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

